

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ,
ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ТАЛААРХ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Байнгын хороо дэмжсэн саналууд:

Нэг.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол

1.Төслийн 4 дүгээр зүйлийн хуулийн дагаж мөрдөх хугацааг “2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс” гэж өөрчлөх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Г.Амартувшин

Хоёр.Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 6¹.1-ийн “баталгаа, батлан даалт гаргана:” гэснийг “даатгагчийн баталгаа, батлан даалт гаргаж болно:” гэж өөрчлөх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Г.Амартувшин

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 6¹.1.1.-ийн “төлбөрийг даатгагчийн баталгаагаар гаргаж болно;” гэснийг “төлбөрт;” гэж өөрчилж, 6¹.1.2, 6¹.1.3 дахь заалтын “даатгагчийн баталгаа гаргаж болно.” гэснийг хасах.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Г.Амартувшин

3.Энэ хуулийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгелдер болсон өдрөөс эхлэн дагаж мөрднө.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Г.Амартувшин

Гурав.Найруулгын санал

1.Төрийн бэлэн орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн төсөл

1.Төслийн гарчгийн “нэмэлт” гэсний дараа “, өөрчлөлт” гэж, төслийн 2 дугаар зүйлийн “бараа, ажил, үйлчилгээ” гэсний дараа “худалдан” гэж нэмж, төслийн 1 дүгээр зүйлийн “4.1.13 дахь хэсэгт заасныг ойлгоно” гэснийг “4.1.13-т заасныг” гэж, төслийн 3 дугаар зүйлийн “хуульд дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:” гэснийг “хуулийн 20.2, 43.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:” гэж өөрчилж, төслийн 2 дугаар зүйлийн “5.1.7, 5.1.8” гэсний дараах “дахь заалт, 5 дугаар зүйлийн” гэснийг хасах.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Г.Амартувшин

2. Даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

1. Төслийн 1 дүгээр зүйлийн “зүйлд заасан зохицуулалтыг хэрэглэнэ” гэснийг “зүйлд заасныг баримтална” гэж, “6.1-д заасан” гэснийг “6.1-д заасан” гэж, төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “үйл ажиллагааны журмыг Санхүүгийн зохицуулах хороо батална” гэснийг “үйл ажиллагааны журам” гэж өөрчилж, төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “даатгагчийн баталгаагаар” гэснийг хасах.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Г.Амартувшин